

БАТЛАВ
МӨРӨН СУМЫН ЗАСАГ
ДАРГА  Х. ТАЙВАНБАЯР

МӨРӨН СУМЫН 14 БАГИЙН АЙЛ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ
ХАЯГДЛЫГ АЧИЖ, ТЭЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА
ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025 оны 01 дүгээр сарын 08

Мөрөн сум

1	Үйлчилгээний байгууллага шалгаруулах үндэслэл	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоол, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар хуралдааны 02 дугаар тогтоол;
2	Захиалагч байгууллага	Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар;
3	Ерөнхий шаардлага	Сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор сумын нутаг дэвсгэр дэх айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, сургалт сурталчилгааг тогтмол явуулах;
4	Байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ хүн ам, аж ахуйн нэгжийн тоо	Мөрөн сумын айл өрх, аж ахуйн нэгжүүдийн тоог уг бичиг баримтын хавсралтаар;
5	Үндсэн үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none">1. Батлагдсан маршрутын дагуу хог ачилтыг зохион байгуулж ажиллах;2. Энгийн болон дахивар хог хаягдал ачих хуваарийг сар, улирал, жилээр гаргаж батлуулан, хуваарийн дагуу ажиллана.3. Энгийн хог хаягдлыг, тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүүмжлэлтэй, технологийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан задгай тэвштэй (хог бүтээх бүтээлэгтэй), шахдаг, чингэлэгтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэх;4. Тээвэрлэх хог хаягдлын төрөл, ангиллыг заасан тэмдэг, тэмдэглэгээ, дуут дохиотой байна.5. Тухай бүсийн нутаг дэвсгэрт үүссэн ил задгай хог хаягдлыг бүрэн цэвэрлэх, ил задгай хоггүй байлгах;6. Хуваарийн дагуу хог ачилтаас зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаантай хоцорсон айл өрх, иргэн, аж ахуйн нэгжтэй эргэн холбогдож хог хаягдлыг тээвэрлэх;7. Ачилтын өмнө ангилан ялгасан хог хаягдлыг тусад нь тээвэрлэх;8. Байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрийн хог хаягдлыг хог хаягдлын бүтэц онцлогт тохирсон хог тээврийн зориулалтын авто машинаар тээвэрлэх;

		<p>9. Мөрөн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан гэрээний дагуу хог тээвэрлэлтийг хийнэ.</p> <p>10. Дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгаж дахивар авах цэгт хүргэж, тушаасан баримтыг авах;</p> <p>11. Батлагдсан төсвийн 2 хувиас хэтрэхгүй мөнгөн дүнг Хог хаягдлын тухай хууль болон холбогдох дүрэм журмыг сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулна. <i>(төлөвлөгөөнд зайлшгүй тусгах)</i></p>
6	Хүний нөөц	<ol style="list-style-type: none"> 1. Механик-1 2. ХАБЭА инженер-1 3. Шуурхай дуудлага хүлээн авах оператор-1 4. Үйл ажиллагаа хариуцсан менежер -1 5. Орлого бүрдүүлэлт хариуцсан ажилтан-2 6. Нягтлан -1 7. Ачигч- 15-аас дээш 8. Жолооч- 10-аас дээш <p>Хог ачилт, тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх, гэрээ байгуулах, айл өрхөөс авах хог хаягдлын үйлчилгээний хураамжийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх, сумын Санхүүгийн алба, Татварын албатай тооцоо нийлэх, Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасаг, багийн дарга нартай хамтран ажиллах; Хүний нөөцийн ажиллах хүчийг тухайн орон нутгаас бүрдүүлж, Мөрөн сумын ЗДТГазраас гэрээ байгуулан ажиллана.</p>
7	Үйл ажиллагаанд байгууллагын мөрдөх, норм, стандарт	<ol style="list-style-type: none"> 1. Монгол улсын Хог хаягдлын тухай хууль 2. Аймгийн ИТХурлын 2019 оны 122 дугаар тогтоол “Энгийн хог хаягдал цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах” журам 3. Хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд ажиллахдаа ХАБЭА болон бусад хууль, дүрэм, журам, стандартыг мөрдөж ажиллах; 4. Стандарт нэвтрүүлсэн бол давуу тал болно. 5. Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, багаж хэрэгслийг бүрэн бүрдүүлж, ХАБЭА, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах; <i>/хамгаалалтын малгай, цацруулагч, байгууллагын логотой ажилтны нэр бүхий ажлын хувцас, бээлий, маск, хамгаалалттай ажлын гутал, хамгаалалтын нүдний шил, хүрз г.м /</i> 6. Хог ачиж цуглуулах, тээвэрлэх үйлчилгээг үзүүлэхдээ харилцааны соёлыг эрхэмлэнэ.
8	Үйлчилгээний байгууллагад тавигдах шаардлага	<ol style="list-style-type: none"> 1. Захиалагчийн тодорхойлолт ирүүлэх; 2. Хог тээвэрлэх зориулалтын чингэлэгтэй авто машин-4 3. Хог тээвэрлэх задгай тэвштэй автомашин-4 4. Хуурай хогийг шахаж нягтруулан ачих машин-2 5. Ковш-1

		<p>6. Хог преслэгчтэй байна.</p> <p>7. Хуванцар бутлагч төхөөрөмжтэй байна.</p> <p>8. Шахагч болон задгай тэвштэй хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэхэд зориулалтын стандартын шаардлага хангасан техник хэрэгсэлтэй байна.</p> <p>9. Хог тээврийн автомашиныг сард 1 удаа, улиралд 4 удаа ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийнэ.</p> <p>10. Тухай нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах ажлын байртай байна.</p> <p>11. Тухайн байгууллага нь засварын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий өөрийн эсвэл түрээсийн гарааштай байх;</p> <p>12. Хог ачиж тээвэрлэх үйл ажиллагаанд ажиллах машин техник нь газар зүйн мэдээллийн (GPS) систем бүхий тоног төхөөрөмжтэй байх;</p>
9	Онцгой нөхцөл	<p>1. Хог хаягдлын мэдлэг олгох, сургалт сурталчилгаа хийх төлөвлөгөөг гаргаж улиралд 1 удаа зохион байгуулан холбогдох тайлан мэдээг зургаар баталгаажуулан ирүүлж, багийн иргэд нийтийн хуралд мэдээлэл өгөх;</p> <p>2. Ангилан ялгасан иргэн аж ахуйн нэгжийг улиралд урамшуулж, олон нийтэд мэдээлэх;</p> <p>3. Хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр 1 багийг сонгон дадал хэвшилд сургаж, үр дүнг тайлагнах;</p> <p>4. Хүний нөөцийг бүрдүүлэхдээ орон нутгийн ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагын үндсэн ажилтнуудаас тухайн чиглэлийн ажил гүйцэтгэж байсан ажилчдыг авч ажиллуулах гэрээг Мөрөн сумын ЗДТГазартай хийх;</p> <p>5. Багуудын хог хаягдлыг тээвэрлэхдээ сумын ЗДТГазартай чингэлэг болон тусгай зориулалтын автомашины гэрээ байгуулан ашиглаж болно.</p> <p>6. Гэрээний дагуу тухайн техник хэрэгслийн эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээг бүрэн хариуцан ажиллана.</p> <p>7. Хог тээврийн ачилт үйлчилгээ үзүүлэхдээ дараах байдлаар төлөвлөж ирүүлэх; Үүнд:</p> <p>а. Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлыг сардаа 1 удаа ачиж, тээвэрлэх;</p> <p>б. Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг сардаа 1 удаа, шаардлагатай тохиолдолд дуудлагаар ачих, аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан тарифыг мөрдөж ажиллана.</p> <p>в. Бүх орон сууцны айл өрхийн хог хаягдлыг хэсэгчилсэн байдлаар төлөвлөн 7 хоногт 2-3 удаа ачиж, тээвэрлэх байдлаар календарчилсан төлөвлөгөөг боловсруулж оршин суугчдад хүргэж ажиллах;</p> <p>г. Бүх нийтийн хог цэвэрлэгээний үед гарах хог хаягдлыг ачиж тээвэрлэж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх;</p> <p>д. Бүх нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярын өдрүүдэд ажиллах ажлын хуваарь гаргах;</p>

		<p>е. Аж ахуйн нэгж, байгууллагуудын хог ачилтыг хийхдээ орчны цэвэрлэгээг тогтмол хийлгүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр заавар, зөвлөмж өгөх;</p> <p>ё. Мөрөн сумын Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан аян, олон нийтийн арга хэмжээнд хамтран зохион байгуулж оролцох;</p> <p>ж. Хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлэлтийг сайжруулах шинэ менежментийг нэвтрүүлэн ажиллах;</p> <p>з. Хог хаягдлын үйлчилгээний орлогын төлөвлөгөөг биелүүлж, үр дүнтэй ажиллах;</p> <p>8. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд хариуцсан бүсийн хог тээвэрлэлт, цуглуулалтын ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн тохиолдолд гэрээг цуцлах бөгөөд гарсан хохирлыг гүйцэтгэгч байгууллага бүрэн хариуцна.</p>
--	--	--

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.АНХЦЭЦЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Н.БОЛОРЖАРГАЛ